



МОНГОЛ УЛСЫН  
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН  
ТУШААЛ

2023 оны 11 сарын 06 өдөр

Дугаар А/130

Улаанбаатар хот

“Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны  
төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн  
баталгааг хангах хөтөлбөр батлах тухай”

Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.1, 9.8, 13 дугаар зүйлийн 13.1, Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг хавсралт ёсоор баталсугай.


2. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөөг жил бүр гарган шаардагдах зардлыг төсөвт тусгах, хөтөлбөрийг цаг үеийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Г.Батбаяр/-т хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж хамтарч ажиллахыг газар, хэлтсийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



С.МАГНАЙСҮРЭН

Төрийн нарийн бичгийн даргын  
2023 оны 11 сарын 06 -ны өдрийн  
А/430 тоот тушаалын хавсралт



**“УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ АЛБАН ХААГЧДЫН АЖИЛЛАХ  
НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨР”**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

**1.1. Эрх зүйн үндэслэл:**

Монгол Улсын Үндсэн хуулийн 46 дугаар 46.3, Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, Төрийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь хэсэг, дөрөвдүгээр хэсгийн 14, 15, 16, 17, 18 дугаар бүлэг болон түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарсан Засгийн газрын тогтоолоор баталсан журмууд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны “Хөдөлмөрийн дотоод журам” болон төрийн албан хаагчтай холбоотой бусад хууль тогтоомж, эрх зүйн баримт бичиг нь энэхүү хөтөлбөрийг боловсруулан баталж, хэрэгжүүлэх эрх зүйн үндэслэл болно.

**1.2. Хамрах хүрээ:**

Энэхүү хөтөлбөрт Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны нийт ажилтан, албан хаагчид хамрагдана.

**Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт**

**2.1.Зорилго:**

2.1.1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны ажилтан, албан хаагчийн ажиллах нөхцөлийг тасралтгүй сайжруулах, нийгмийн баталгааг хангах зорилтуудыг хэрэгжүүлснээр албан хаагч нь төрд алба хашиж буй нийгмийн гишүүнийхээ хувьд сэтгэл ханамжийн баталгаатай байх нөхцөлийг бүрдүүлнэ.

2.1.2. Албан хаагчдыг ажлын байрны тодорхойлолтын дагуу эрхэлсэн ажлаа мэргэжлийн өндөр түвшинд чанартай гүйцэтгэх боломжийг бүрдүүлэх үүднээс нийгмийн баталгааг нь хууль тогтоомжийн хүрээнд хангах талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны баримтлах бодлогыг тодорхойлоход оршино.

2.1.3. Төрийн албаны чадахуйн /мерит/ зарчмын хүрээнд шударга нээлттэй, үл ялгаварласан тэгш байх зарчмыг хэрэгжүүлнэ.

**2.2. Зорилт:**

2.2.1. Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах үйл ажиллагааны чиглэл, Төрийн албаны тухай хууль, төрийн албаны чадахуйн/мерит/ зарчим, болон бусад хууль тогтоомжоор хамгаалагдсан яамны албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах арга замыг тодорхойлно.

## Гурав. Хөтөлбөрийн зарчим, зохион байгуулалт

### 3.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим:

3.1.1. төрийн албаны тухай хууль, төрийн албан хаагчтай холбоотой хууль тогтоомжийг дээдлэн чанд мөрдөх;

3.1.2. албан хаагч нэг бүрийг хамруулах;

3.1.3. ил тод, шударга, тэгш, нээлттэй хүртээмжтэй байх;

3.1.4. бодитой байх;

3.1.5. өөрийн нөөц бололцоог бүрэн дайчлах;

3.1.6. судалгаа, шинжилгээнд тулгуурлах;

3.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг Төрийн захиргааны удирдлагын газар болон бусад газар, хэлтэстэй хамтран төлөвлөгөө гарган хэрэгжилтийг зохион байгуулна.

### Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

#### 4.1. Ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх чиглэлээр:

4.1.1. Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах асуудлыг Төрийн албаны тухай хууль, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ.

#### 4.2. Ажлын байрны нөхцөл, баталгаа:

4.2.1. Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Яамны Хөдөлмөрийн дотоод журамд зааснаас бусад тохиолдолд төрийн албанаас үндэслэлгүй халагдахгүй байх;

4.2.2. Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөсөн төрийн жинхэнэ албан хаагчийн орон тоо, албан тушаалыг Төрийн албаны тухай хууль Хөдөлмөрийн тухай хуульд заасан холбогдох нөхцөл болзлын дагуу хадгална.

4.2.3. Албан хаагчдын чадавхыг дээшлүүлэх чиглэлээр тасралтгүй мэргэшүүлэх сургалтад хамруулах, тэднийг бие дааж мэдлэг чадвараа дээшлүүлэх сургалтад хамрагдах нөхцөл бололцоогоор хангаж дэмжлэг үзүүлнэ.

4.2.4. Төрийн албан хаагчдын ур чадвар, ажлын үр дүн, туршлагыг үндэслэн шатлан дэвшүүлэх зарчмыг хэрэгжүүлэх.

4.2.5. Албан хаагчдад ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох, яамны албан тушаалын зэрэг дэв шинээр олгох, ахиулах, шагналд нэр дэвшүүлэх, гадаад оронд сургалтад хамруулах, туршлага судлуулах зэргээр хууль тогтоомжид нийцүүлэн урамшуулна.

4.2.6. Хөдөлмөрийн хуулиар тогтоосон ээлжийн амралтыг олгоно.

4.1.2.7. Албан үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан хүчирхийлэх, заналхийлэх, доромжлох, гүтгэх болон хууль бус үйлдэл, үйл ажиллагаанаас яамны албан хаагч, түүний гэр бүлийн гишүүнийг хамгаална.

#### 4.3. Хөдөлмөрийн нөхцөл, баталгаа:

4.3.1. Яамны албан хаагч нь албан хаагчийг стандартын шаардлага хангасан өрөө, тасалгаа, хурал, зөвлөгөөн, уулзалтын танхим, ариун цэврийн өрөө, гэрэлтүүлэг, тохижилт зэрэг ажиллах нөхцөлийг бүрэн хангана.

4.3.2. Албан хаагчдыг ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай тавилга, компьютер, техник хэрэгслээр хангах асуудлыг ажилтнуудаас санал авч судалгаа хийсний үндсэн дээр жил бүрийн төсөвт тусгах замаар шийдвэрлэнэ.

4.3.3. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны албан хаагчдыг номын сан, архиваар нээлттэй үйлчлүүлэх боломжийг бүрдүүлнэ.

#### **4.4. Нөхөх олговор олгох, хөнгөлөлтийн талаар:**

4.4.1. Яамны албан хаагчдад Төрийн албаны тухай хуулийн 59.1-т заасны дагуу дараах нөхөх олговрыг олгоно. Үүнд:

а/ албан томилолтын зардлыг;

б/ албан ажлын хэрэгцээнд хувийн унаа хэрэглэсэн тохиолдолд батлагдсан нормативын дагуу гарсан зардлыг;

в/ гадаад улсад болон нэг аймаг хотоос нөгөө аймаг, хотод, түүнчлэн аймаг, хот дотор ажиллахаар томилогдсон албан хаагчид тээврийн хэрэгсэл, ачаа тээш, зам хоногийн зардал, түүний гэр бүлийн болон асрамжид нь байдаг хүмүүст тээврийн хэрэгсэл, ачаа тээшний зардлыг;

г/ Төрийн албаны тухай хуулийн 59.1.4, 59.1.5, 59.1.6-д заасан нөхөх олговрыг олгоно.

4.4.2. Албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажиллах нөхцөлөөр хангах, гүйцэтгэж байгаа албан тушаалын чиг үүргийг харгалзан зохих журмын дагуу албаны унаа хэрэглэх, ажилдаа ирэх, буцах нийтийн тээврийн унааны зардлын зохих хэсгийг олгоно.

4.4.3. Тухайн жилийн сургалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу харьяалах газар, хэлтсийн дарга болон Төрийн нарийн бичгийн даргын саналыг үндэслэн Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар яаманд 3-аас доошгүй жил тогтвортой ажиллаж байгаа албан хаагч мэргэжлийнхээ чиглэлээр дотоодод магистр, докторын сургалтад хамрагдсан тохиолдолд сургалтын төлбөрийн 30-100 хүртэл хувийн хөнгөлөлт үзүүлнэ.

4.4.4. Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасан тухайн жилийн эмчилгээний төлбөрийн хэмжээнээс давсан хэсэг болон магадлан итгэмжлэл бүхий эмнэлгийн байгууллагын шийдвэрээр гадаад оронд эмчлүүлэх зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд зардлын 60 хувийг байгууллага хариуцна.

4.4.5. Яамны албан хаагчдад нийтийн тээврийн унааны, хоолны үнийн хөнгөлөлт олгож, зах зээлийн үнийн өсөлт, мөнгөний инфляцтай уялдуулан тухай бүр нэмэгдүүлнэ.

#### **4.1.5. Цалин хөлсний талаар:**

4.5.1.Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, УИХ-ын болон Засгийн газрын тогтоол, шийдвэрийг үндэслэн албан хаагчдын цалин хөлсийг Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар зохих журмын дагуу тогтоож олгоно.

4.5.2. Албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түшингийн үнэлгээ, ур чадвар, ажлын туршлагатай нь уялдуулан албан тушаалын үндсэн цалингийн шатлалыг ахиулна.

4.5.3.Ажилтнуудад ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох, төрийн албан хаагчийн албан тушаалын зэрэг дэв ахиулах, зэргээр хууль тогтоомжид нийцүүлэн урамшуулна.

4.5.4.Хөдөлмөрийн хуульд заасны дагуу ээлжийн амралтын нөхөн олговор олгоно.

4.5.5.Цалингийн зээл авахад нь байгууллагаас дэмжлэг үзүүлнэ.

#### **4.6. Буцалтгүй тусламж олгох:**

4.6.1. Өндөр насны тэтгэвэрт гарч байгаа ажилтан, албан хаагчдад Төрийн албаны тухай хуулийн 60.1-т заасны дагуу 36 хүртэл сарын үндсэн цалинтай тэнцэх нэг удаагийн буцалтгүй тусламж олгоно.

4.6.2. Албан хаагч, түүний гэр бүлийн гишүүн, төрөл садан /эцэг, эх, эхнэр, нөхөр, төрсөн ах, эгч, дүү, хүүхэд, өвөг эцэг, эмэг эх/-гийн хүн нь нас барах, өвчний улмаас хөдөлмөрийн чадваргүй болсон гэр бүлийн гишүүнээ тэтгэхэд нь зориулж хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх хүртэл хэмжээний мөнгөн тусламж;

4.6.3. Албан хаагчийн өрхийн орлого буурч, нэг гишүүнд ногдох хэмжээ нь амьжиргааны баталгаажих доод түвшинд хүрэхгүй болсон тохиолдолд гэр бүлийг нь дэмжихэд зориулан тухайн албан хаагчийн нэг сарын албан тушаалын цалингаас нь хэтрүүлэхгүйгээр жилд 1 удаа буцалтгүй тусламж;

4.6.4. Ээлжийн амралтаараа өөрийн буюу эхнэр /нөхөр/-ийн төрсөн нутагт явах бол ирэх, очих замын зардлыг, эсхүл магадлан итгэмжлэл бүхий эмнэлгийн байгууллагын шийдвэрээр дотоодын сувилалд ирэх, очих замын зардлыг авто машин, төмөр замын тээврийн тухайн үед мөрдөж байгаа энгийн үнэлгээгээр тооцож хоёр жилд 1 удаа;

4.6.5. Байгалийн давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэнэтийн аюулд өртөн ар гэрт нь эд материалын хохирол учирсан нь тогтоогдсон бол тухайн албан хаагчид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хүртэл хэмжээний мөнгөн тусламж;

4.6.6. Эхнэр нь амаржсан үед болон нэг хүртэлх настай хүүхэд үрчилж авахад ажлын 5 хоногийн цалинтай чөлөө олгож, хүүхэд тус бүрд 500000 төгрөгийн тусламж;

4.6.7. Албан хаагчийн гэр бүл болох хуримын ёслолд нь зориулж хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх хэмжээгээр мөнгөн тусламж;

4.6.8.Тухайн жилд батлагдсан төсвийн хүрээнд багтсан ердийн галлагаатай гэр, сууцанд амьдардаг албан хаагчийн түлшний зардлын тодорхой хувьтай тэнцэх мөнгөн тусламжийг жилд 1 удаа өвлийн улиралд олгож болно;

4.6.9.Албан хаагч хүндээр өвдөн 1 сараас дээш хугацаагаар албан үүргээ гүйцэтгэж чадахгүй болох, албан үүргээ гүйцэтгэх явцад, эсхүл яамны болон яамыг

төлөөлөн тэмцээн, уралдаанд оролцох явцад бэртэж, гэмтвэл нэг сарын албан тушаалын цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тусламж олгож болно.

#### **4.7. Албан хаагчдыг орон сууцаар хангах, амьдралын нөхцөлийг сайжруулах чиглэлээр:**

4.7.1. Яамны албан хаагчдын орон сууцны судалгааг жил бүр нарийвчлан гаргаж, түүнд үндэслэн яаманд тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллаж байгаа албан хаагчийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд нь зориулж орон сууц, зуслангийн газар, хашаа, байшин, худалдан авах, барих, орон сууцны нөхцөлөө сайжруулахад нь мөнгөн болон бусад дэмжлэг үзүүлнэ. Энэ дэмжлэгийг үзүүлэх албан хаагчийг сонгохдоо дор дурдсан шаардлагын аль нэгийг харгалзан үзнэ. Үүнд:

4.7.1.1. Хувийн орон сууц, хашаа, байшингүй эсвэл ам бүл олуулаа амьдардаг, амьдралын нөхцөл муу, орон сууцны нөхцөлөө сайжруулах шаардлагатай байгаа;

4.7.1.2. Албан тушаалын тодорхойлолт, үр дүнгийн гүйцэтгэлээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж, тавигдсан шаардлагыг хангаж, үр бүтээлтэй ажиллаж байгаа;

4.7.1.3. Төрийн албанд 5-аас доошгүй жил, яаманд 3-аас доошгүй жил тогтвор суурьшилтай ажиллан цаашид үргэлжлүүлэн ажиллах хүсэл эрмэлзэлтэй.

4.7.1.4. Гэрт буюу ердийн галлагаатай сууцанд амьдардаг ажилтанд жилд нэг удаа түлээ, нүүрсний хөнгөлөлт үзүүлнэ. /улсаас буюу байгууллагаас орон сууц, орон сууцны хөнгөлөлт авсан, эсвэл нийтийн төвлөрсөн халаалттай орон сууцанд амьдардаг хүмүүс энэ заалтад хамаарахгүй/

4.7.1.5. Яамны албан хаагчдыг орон сууцжуулах талаар бодлого боловсруулж шинээр орон сууц барихтай холбоотой асуудлыг төсөв болон олон улсын төсөл хөтөлбөрийн хүрээнд шийдвэрлэх талаар анхаарна.

4.7.1.6. Яамны албан хаагчдыг орон сууцны жилийн 6 хувийн хүүтэй зээлд хамруулах талаар арилжааны банкнуудтай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллана.

4.7.1.7. Яамны албан хаагчдыг нэгдсэн журмаар зуслангийн газартай болгох асуудлыг тухай бүр шийдвэрлэж байна.

#### **4.8. Албан хаагчдыг сургаж, мэргэшүүлэх чиглэлээр:**

4.8.1. Салбарын хүний нөөцийн судалгаа, бодлого, төлөвлөгөөнд үндэслэн сургалтын хөтөлбөр боловсруулж, төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх, давтан сургах, мэргэшил дээшлүүлэх сургалтыг үе шаттайгаар зохион байгуулна.

4.8.2. Ажилтнуудын гадаад хэлний мэдлэг, боловсролыг дээшлүүлэхэд анхаарч дэмжлэг үзүүлнэ.

4.8.3. Төрийн болон өөрийн хөрөнгөөр давтан сурах, мэргэшлээ дээшлүүлэх, энэ хугацаанд тэднийг ажлаас нь түр хугацаагаар чөлөөлөх, эрхэлж байгаа албан

тушаалын цалин хөлсийг олгох зэргээр төрийн албан хаагчийг мэдлэг, мэргэшлээ дээшлүүлэх нөхцөл бололцоогоор хангана.

4.8.4. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны албан хаагчдын сургалтын журам, төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулна.

4.8.5. Шинээр ажилд томилогдсон ажилтанд яамны үйл ажиллагааны стратеги, чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, байгууллагын соёл, хөдөлмөрийн дотоод журам болон төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм, албан хэрэг хөтлөлт зэрэг шаардлагатай мэдээллийн талаар “ажлын байран дахь сургалт” хийнэ.

4.8.6. Гадаад оронд сургалтад хамруулах, туршлага судлуулах

#### **4.9. Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр:**

4.9.1. Албан хаагчдыг жилд 1-ээс доошгүй удаа эрүүл мэндийн үзлэг, нарийн мэргэжлийн шинжилгээ, оношилгоонд хамруулна. Энэ талаар тодорхой хэмжээний зардлыг жил бүр яамны төсөвт тусгана.

4.9.2. Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор эмчийн орон тоог бий болгож, яамны албан хаагчдад эмнэлгийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх, эрүүл мэндийн зөвлөгөө өгөх, шаардлагатай тохиолдолд албан хаагчдыг өдрийн эмчилгээнд хамруулж, эмийн ба эмийн бус эмчилгээ, сувилгаа хийх ажлыг зохион байгуулна.

4.9.3. Ажлын байрны эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах, ажилтнуудын дунд спортын уралдаан тэмцээн зохион байгуулах, долоо хоногийн нэг өдөрт спорт зааланд тоглуулдаг байх(спортын байгууллагатай тогтмол гэрээтэй ажиллах);

4.9.4. Эрүүл мэндийн даатгалын тооцоог сар бүр нийгмийн даатгалын байгууллагатай хийж холбогдох эрх бүхий байгууллагаар баталгаажуулж, төрөөс үнэ төлбөргүй эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

4.9.5. Төрийн албаны тухай хуулийн 59.1.7 дахь заалтын дагуу Эрүүл мэндийн даатгалын хуульд заасан тухайн жилийн эмчилгээний төлбөрийн хэмжээнээс давсан хэсэг болон магадлан итгэмжлэл бүхий эмнэлгийн байгууллагын шийдвэрээр гадаад оронд эмчлүүлэх зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд зардлынх нь 60-аас доошгүй хувийг хариуцна.

4.9.6. “Эрүүл агаар эм” сэдэвт идэвхтэй амралт, явган болон тойрон аяллыг жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулна.

4.9.7. “Эрүүл аж төрөх ёс”, “Зөв хооллолт” зэрэг сэдвийн хүрээнд мэргэжлийн хүмүүсийг урьж яамны албан хаагчдад сургалт зохион байгуулна.

4.9.8. Байгууллагын дэргэд чийрэгжүүлэлтийн болон биеийн тамир спортын заалтай болох асуудлыг холбогдох газарт тавьж шийдвэрлүүлэх.

#### **4.10. Албан хаагчдын чөлөөт цагийг үр ашигтай өнгөрүүлэх чиглэлээр:**

4.10.1.Баяр ёслол, тэмдэглэлт ой, амралтын өдрүүдийг хамт олноороо тэмдэглэн өнгөрүүлэх, аялал зугаалга, урлаг спортын арга хэмжээ зохион байгуулах зэргээр албан хаагчдын ая тухтай, зөв зохистой амрах, алжаалаа тайлах нөхцөл бололцоогоор хангана.

### **Тав. Хөтөлбөрийн санхүүжилт**

5.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:

- 5.1.1. яамны жил бүрийн төсөвт тусгах;
- 5.1.2. яамны төсвийн хэмнэлт, үйл ажиллагааны нэмэлт орлогын тодорхой хувийг зарцуулах /Сангийн яамтай тохиролцсоны үндсэн дээр/;
- 5.1.3. төсөл, хөтөлбөр;
- 5.1.4. олон улсын зээл тусламж;
- 5.1.4. бусад эх үүсвэр;

### **Зургаа. Хөтөлбөрийн хэрэгжих үе шат, хугацаа**

6.1. Энэхүү хөтөлбөрийг 2023-2028 онд хэрэгжүүлнэ.

### **Долоо. Хөтөлбөрийн хяналт-шинжилгээ үнэлгээ**

7.1. Яамны Төрийн захиргааны удирдлагын газар хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулж, биелэлтэд нь хяналт тавин үр дүнгийн талаар жил бүр Сайд, Төрийн нарийн бичгийн даргад танилцуулж байна.

7.2. Хөтөлбөрийн хэрэгжилтэд 2 жил тутам яамны хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийж, дүнг Сайд, Төрийн нарийн бичгийн даргын зөвлөлд танилцуулж байна.

7.3. Зайлшгүй шаардлагатай үед хөтөлбөрт өөрчлөлт оруулж болно.

### **Найм. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хүрэх үр дүн**

8.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны албан хаагчдын ажлын бүтээмж дээшилж, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдэнэ.

8.2. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэлийн үр дүн сайжирч, шударга ёс, ил тод нээлттэй байх нөхцөл бүрдэнэ.

8.3. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны хэмжээнд чадахуйн зарчим /мерит/ хэрэгжиж, ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа хангагдана.

---oOo---